5. Дүүргийн төсвийн орлогоор 2012 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.БАТБИЛЭГ

2B  
172

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2012 оны 11 сарын 02  
10 дугаар тогтоолын хавсралт

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2012-2013 ОНД ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг
1	4, 83-р цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	49.6
2	18, 31, 37, 108-р цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	49.5
3	39, 56, 173-р цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	41.4
4	9, 70-р цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	49.2
5	33, 124-р цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	49.4
6	Сайн хөрш цэцэрлэгт нэн шаардлагатай хатуу эдлэл	2012-2013	10.9
7	49-р сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	48.0
8	50-р сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	50.0
9	57-р сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	50.0
10	72-р сургуулийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	48.0
11	33-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	46.0
12	37-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	40.0
13	39-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	40.0
14	56-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	40.0
15	70-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	46.0
16	74-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	48.0

17	108-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар	2012-2013	48.0
18	Чингэлтэй хайрхан уулыг ойжуулах төсөл	2012-2013	100.0
19	Хороодод 1 цонхны үйлчилгээний тавилга хэрэгсэл авах	2012-2013	70.0
20	Дүүргийн цагдаагийн хэлтэст автомашин	2012-2013	60.0
21	Спорт заалны шал засвар /5-р сургууль/	2012-2013	50.0
22	Дүүргийн шүүхийн материаллаг баазыг бэхжүүлэх, тавилга, тоног төхөөрөмж	2012-2013	50.0
23	Дүүргийн прокурорын газрын байрны урсгал засвар, тавилга, тоног төхөөрөмж	2012-2013	50.0
24	Бохирын цооног, халаалтын зуух солих ажил /173-р цэцэрлэг/	2012-2013	50.0
25	Сургуулиудыг интернет шилэн кабелиар холбох	2012-2013	32.2
26	Компьютер, техник хэрэгсэл /Шашны 112-р сургууль, Гэгээрэл хөгжил төв/	2012-2013	30.0
27	Татварын хэлтсийн ажлын хэрэгцээнд автомашин	2012-2013	25.0
28	Онцгой байдлын хэлтсийн ажлын хэрэгцээнд автомашин	2012-2013	24.0
29	Эрүүл мэндийн нэгдлийн 2-р амбулторын засвар, техник тоног төхөөрөмж	2012-2013	23.0
30	4-р хороо 18/1, 12а байрны дулаан, ус хангамжийн төхөөрөмжүүдийг шинэчлэх	2012-2013	15.0
31	6-р хорооны 33а байрны фасадны ажилд нэмэлт санхүүжилт	2012-2013	15.0
32	Улаан загалмайн хороо	2012-2013	10.0
33	Ахмадын амралтын трансформатор шинэчлэх	2012-2013	48.0
34	Хуучин байрыг дулаанд холбох /61-р сургууль/	2012-2013	10.0
35	Сантехник засвар /33-р цэцэрлэг/	2012-2013	5.3
36	Бүжгийн хувцас	2012-2013	5.0
37	7-р хороонд цэцэрлэг, сургууль барих газрын хашаажуулах ажил	2012-2013	50.0
38	Хороодын цахилгааны хэт ачаалалтай станцуудын ачааллыг хөнгөлөх чиглэлээр дэд станцыг өргөтгөх	2012-2013	70.0
39	Гэр хороололд 2 гудамж тохижуулах /14, 17-р хороо/	2012-2013	300.0
	<b>Дүн</b>		<b>1,846.5</b>



175 25

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2012 оны 10 сарын 12 өдрийн  
0.6 дугаар тогтоолын хавсралт

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГООР 2012, 2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2012 онд санхүүжих
1	Хороодын гудамж талбайд гэрэлтүүлэг хийх 7,11,15,16,17,18,19-р хороод/	2012-2013	1150.0	
2	Сургууль цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний засвар, /49,50,57,72 дугаар сургуулиуд, 33,37,39,56,70,74,108,103 дугаар цэцэрлэгүүд	2012-2013	543.0	
3	Хороодын цахилгааны хэт ачаалалтай станцуудын ачааллыг хөнгөлөх чиглэлээр дэд станцуудыг өргөтгөх	2012-2013	400.0	
4	Цэцэрлэгүүдийн хатуу эдлэл/4,9,18,31,33,37,39,56,70,83,108,124,173, Сайн хөрш цэцэрлэгүүд/	2012	250.0	
5	Цагдаагийн хэлтсийн 1-р тасагт камержуулалтын хяналтын төв байгуулах	2012-2013	250.0	
6	Иргэдийн чийрэгжилт, хүүхдийн тоглоомын талбай байгуулах тохижилтын ажил /6 дугаар хороо/	2012	150.0	
7	Тохижилтын ажил /24 дүгээр сургууль/	2012	150.0	
8	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах тохижилтын ажил /9-р хороо 31-р цэцэрлэгийн гадна талбайд/	2012	135.0	
9	Чингэлтэй хайрхан уулыг ойжуулах төсөл	2012	100.0	
10	Хороодод 1 цонхны үйлчилгээний тавилга хэрэгсэл авах /7-н хороо*10 сая ₮/	2012	70.0	
11	Иргэдийн чийрэгжилт, хүүхдийн тоглоомын талбай байгуулах тохижилтын ажил /7 дугаар хороо/	2012	50.0	
12	7.12.16.17 дугаар хорооны цагдаагийн хэсэгт автомашин	2012	60.0	
13	Спорт заалны шал засвар /5-р сургууль/	2012	50.0	

14	Дүүргийн шүүхийн материаллаг баазыг бэхжүүлэх, тавилга тоног төхөөрөмж худалдан авах	2012	50.0	
15	Дүүргийн прокурорын газрын байрны урсгал засвар, тавилга тоног төхөөрөмж авах,	2012	50.0	
16	5-р хорооны цогцолбор байрны суурийн бэхэлгээ хийх	2012	50.0	
17	Бохирын цооног, халаалтын зуух солих /173 дугаар цэцэрлэг	2012	50.0	
18	Сургуулиудыг интернет шилэн кабелиар холбох	2012	32.2	
19	Бохирын цооног байгуулах /103 дугаар цэцэрлэг/	2012	30.0	
20	Компьютер техник хэрэгсэл /112 дугаар сургууль/	2012	30.0	
21	Татварын хэлтсийн ажлын хэрэгцээнд автомашин авах	2012	25.0	
22	Онцгой байдлын хэлтсийн ажлын хэрэгцээнд автомашин авах	2012	24.0	
23	Улаан загалмайн хороо	2012	24.0	
24	Эрүүл мэндийн нэгдлийн 2-р амбулторын засвар, техник тоног төхөөрөмж	2012	23.0	
25	4-р хороо 18/1, 12а байрны дулаан, ус хангамжийн төхөөрөмжүүдийг шинэчлэх	2012	15.0	
26	Халаалтын бойлуур солих /9 дүгээр цэцэрлэг	2012	12.0	
27	Хуучин байрыг дулаанд холбох /61 дүгээр сургууль	2012	10.0	
28	Бүжгийн хувцас /50 дугаар сургууль/	2012	8.0	
29	Дулааны тоолуур солих /33 дугаар цэцэрлэг	2012	5.3	
	<b>Дүн</b>		<b>3,796.5</b>	<b>-</b>

175 27



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг сонгох 7 дахь удаагийн сонгуулиар Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрүүлэх тухай дүүргийн сонгуулийн хорооны дарга Н.Наранчулууны илтгэлийг хэлэлцээд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 54.8, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1а дахь заалтыг үндэслэн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон хавсралтанд нэр дурьдсан 35 Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ц.РЭНЦЭНДОРЖ



2150010056



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2012 оны 12 сарын 10-ны өдрийн Анхдугаар  
хуралдааны 01 дугаар тогтоолын хавсралт

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд  
сонгогдсон Төлөөлөгчдийн нэрс

Д/д	Төлөөлөгчдийн овог, нэр	Сонгогдсон хороо	Намын харъяалал
1	Цэрэндашийн Эрдэнэбаяр	1-р хороо	МАН
2	Содномбалжирын Мөнгөнсар	2-р хороо	АН
3	Жамсрангийн Чимэдцогзол	3-р хороо	МАН
4	Батсайханы Амартүвшин	4-р хороо	АН
5	Мягмаржавын Эрхэмбаяр	5-р хороо	АН
6	Чадраабалын Болормаа	6-р хороо	МАН
7	Цэвээний Дуламжав	7-р хороо	МАН
8	Цэнд-Аюушийн Ганболд	7-р хороо	АН
9	Лувсанцэдэнгийн Баярсайхан	8-р хороо	МАН
10	Цэрэндэлэгийн Бугасүрэн	9-р хороо	МАН
11	Жавзийн Лхагвасүрэн	10-р хороо	МАН
12	Дэмбэрэлийн Отгонбаатар	11-р хороо	МАН
13	Жамсрангийн Оюунцэцэг	12-р хороо	МАН
14	Чимэдбатын Дэчингалсан	12-р хороо	МАН
15	Цээрэгзэнгийн Отгонбаатар	13-р хороо	АН
16	Лхамжавын Давийчомбо	14-р хороо	МАН
17	Пүрэвдоржийн Батбаяр	15-р хороо	АН
18	Дамжингийн Бат-Эрдэнэ	16-р хороо	МАН
19	Дэлэгпунцагийн Ядамжав	16-р хороо	МАН
20	Батдэлгэрийн Сарангоо	17-р хороо	МАН
21	Ванданчимэдийн Хүрэлбаатар	17-р хороо	МАН
22	Ёндонбалын Отгонбаяр	18-р хороо	МАН
23	Нэргүйн Оюунгэрэл	19-р хороо	МАН
24	Лхагвасүрэнгийн Баяртулга	Намын жагсаалтаар	МАН
25	Чимэдийн Буянжаргал	Намын жагсаалтаар	МАН
26	Цэрэндоржийн Рэнцэндорж	Намын жагсаалтаар	МАН
27	Бямбаагийн Бат-Ирээдүй	Намын жагсаалтаар	МАН
28	Сосорбарамын Энхтайван	Намын жагсаалтаар	МАН
29	Батын Батбаатар	Намын жагсаалтаар	АН
30	Дагвын Алтанхуяг	Намын жагсаалтаар	АН
31	Лхамсүрэнгийн Энхтуяа	Намын жагсаалтаар	АН
32	Батын Батхуяг	Намын жагсаалтаар	АН
33	Цэнд-Аюушийн Энхжаргал	Намын жагсаалтаар	АН
34	Цэндийн Содхүү	Намын жагсаалтаар	МАХН
35	Үрчгэрийн Тэгшбаатар	Намын жагсаалтаар	МАХН



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Хуралдааны дотоод журам батлах тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны дотоод журмыг хавсралт ёсоор баталсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ц.РЭНЦЭНДОРЖ



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн  
анхдугаар хуралдааны ~~1~~ 2 дугаар тогтоолын  
хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН 7 ДАХЬ УДААГИЙН  
СОНГУУЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААНЫ ДОТООД ЖУРАМ

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны сонгуулийн дүн, Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолын төсөл /10 минут/

/Илтгэгч нь дүүргийн сонгуулийн хорооны дарга Н.Наранчулуун/

2. Намын бүлэг байгуулсан тухай танилцуулахад цаг тогтоохгүй.

3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад нэр дэвшүүлэх, сонгож батлахад цаг тогтоохгүй.

4. Дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх, тогтоол батлахад цаг тогтоохгүй.

5. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгож батлахад цаг тогтоохгүй.

6. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан амаар болон бичгээр асуулт асууж, хариултыг тухай бүрд нь авна.

7. Санал шүүмжлэл, үг хэлэхэд эхний удаад Төлөөлөгч бүрд 7 хүртэл минут, 2 дахь удаад 3 хүртэл минут байна.

8. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан намын бүлгүүд завсарлага авч болох бөгөөд хэрэв завсарлага авах бол хугацааг намын бүлгийн ахлагч Хуралдаан даргалагч /Хурлын дарга/-тай зөвшилцөж тогтооно.

9. Хурлаас гарах тогтоолын төслийг хэлэлцэж батлахад цаг тогтоохгүй.

10. Хуралдааныг 3 цаг тутамд 15 минутын завсарлагатай явуулна. 13.30-15.30-д үдийн завсарлага хийнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хуралдаанаар хэлэлцэх асуудлын  
төлөвлөгөөг батлах тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Ц.РЭНЦЭНДОРЖ

*[Handwritten signature]*





Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн  
анхдугаар хуралдааны 3 дугаар тогтоолын  
хавсралт

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН 7 ДАХЬ УДААГИЙН  
СОНГУУЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгож батлах тухай
3. Дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлж, Нийслэлийн Засаг даргад уламжлах тухай
4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг сонгож батлах тухай
5. Тооллогын комисс байгуулах тухай



131-33



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

- Ч.Болормаа-Төлөөлөгч
- С.Мөнгөнсар-Төлөөлөгч
- Ү.Тэгшбаяр-Төлөөлөгч
- Д.Нарангэрэл-Хурлын ажлын албаны ажилтан
- М.Туяа-Хурлын ажлын албаны ажилтан

ХУРЛАЛДААН ДАРГАЛАГЧ



Ц.РЭНЦЭНДОРЖ

2150010062



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хурлын Тэргүүлэгчдийг сонгож батлах тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанд оролцогчдын олонхийн санал авсан дараах Төлөөлөгчдийг Хурлын Тэргүүлэгчээр сонгож баталсугай.

- 1. Д.Бат-Эрдэнэ /МАН/
- 2. Ж.Лхагвасүрэн /МАН/
- 3. Ж.Чимэдцогзол /МАН/
- 4. Ц.Содхүү /МАХН/
- 5. Ч.Буянжаргал /МАН/
- 6. Ц.Ганболд /АН/
- 7. Б.Батхуяг /АН/

Хоёр. Хууль тогоомжийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлж, идэвх санаачлагатай ажиллахыг Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Хурлын хороо байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1в, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дараах хороодыг байгуулж ажиллуулахаар шийдвэрлэсүгэй. Үүнд:

- 1.1. Эрх зүй, төрийн байгууллагын асуудал эрхэлсэн хороо
- 1.2. Эдийн засаг, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн хороо
- 1.3. Төсвийн зарцуулалтын хяналтын асуудал эрхэлсэн хороо
- 1.4. Байгаль орчин, экологийн асуудал эрхэлсэн хороо
- 1.5. Дэд бүтэц, тохижилт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн асуудал эрхэлсэн хороо
- 1.6. Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороо
- 1.7. Иргэний оролцоо, санал хүсэлтийн хороо

2. Хороодын бүрэлдэхүүнд дараах Төлөөлөгчдийг баталсугай. Үүнд:

- 2.1. Эрх зүй, төрийн байгууллагын асуудал эрхэлсэн хороо:
  - Ц.Рэнцэндорж-Дарга
  - Д.Ядамжав-Гишүүн
  - Б.Бат-Ирээдүй-Гишүүн
  - Ч.Дэчингалсан-Гишүүн
  - Б.Батбаатар-Гишүүн
  - Ц.Ганболд-Гишүүн
  - М.Эрхэмбаяр-Гишүүн
- 2.2. Эдийн засаг, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн хороо:
  - Л.Баярсайхан-Дарга
  - Н.Оюунгэрэл-Гишүүн
  - Ж.Чимэдцогзол-Гишүүн

- С. Энхтайван-Гишүүн
- Л. Энхтуяа-Гишүүн
- Б. Амартүвшин-Гишүүн
- Б. Батхуяг-Гишүүн

3. Төсвийн зарцуулалтын хяналтын асуудал эрхэлсэн хороо:

- Б. Батбаатар-Дарга
- Ч. Буянжаргал-Гишүүн
- Д. Отгонбаатар-Гишүүн
- Ж. Лхагвасүрэн-Гишүүн
- Д. Алтанхуяг-Гишүүн
- С. Мөнгөнсар-Гишүүн
- Л. Энхтуяа-Гишүүн

4. Байгаль орчин, экологийн асуудал эрхэлсэн хороо:

- Л. Давийчомбо-Дарга
- Л. Баяртулга-Гишүүн
- С. Энхтайван-Гишүүн
- Ё. Отгонбаяр-Гишүүн
- П. Батбаяр-Гишүүн
- Ц. Энхжаргал-Гишүүн
- Б. Амартүвшин-Гишүүн

5. Дэд бүтэц, тохижилт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн асуудал эрхэлсэн хороо:

- Д. Алтанхуяг-Дарга
- Ж. Оюунцэцэг-Гишүүн
- Ц. Бугасүрэн-Гишүүн
- Ц. Дуламжав-Гишүүн
- Ц. Эрдэнэбаяр-Гишүүн
- П. Батбаяр-Гишүүн
- Ц. Отгонбаатар-Гишүүн

6. Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороо:

- Ү. Тэгшбаатар-Дарга
- Ц. Содхүү-Гишүүн
- Ч. Дэчингалсан-Гишүүн
- Ё. Отгонбаяр-Гишүүн
- В. Хүрэлбаатар-Гишүүн
- Л. Баярсайхан-Гишүүн
- С. Мөнгөнсар-Гишүүн

7. Иргэний оролцоо, санал хүсэлтийн хороо

- Ч. Болормаа-Дарга
- Д. Бат-Эрдэнэ-Гишүүн

- Б.Сарангоо-Гишүүн
- Ц.Эрдэнэбаяр-Гишүүн
- Б.Батхуяг-Гишүүн
- Ц.Ганболд-Гишүүн
- Ц.Энхжаргал-Гишүүн

3. Хууль тогтоомжийн хүрээнд, идэвх санаачлагатай ажиллаж, ажлаа Хуралд хагас жил тутамд тайлагнаж байхыг Хороодын дарга нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын дүрэм батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хурлын дүрмийг мөрдөж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын ажлын албаны ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Хурлын хуралдааны дэг, ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг энэхүү дүрэмд нийцүүлэн шинэчлэн боловсруулахыг Хурлын ажлын алба /Н.Наранчулуун/-д даалгасугай.
4. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ХУРЛЫН ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 12 сарын 20 өдрийн 9 дугаар тогтоолын хавсралт



**Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэм**

**Нэг. Нийтлэг үндэслэл.**

1.1. Энэхүү дүрмийн зорилт нь Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчид, хороо, түр хороо, ажлын хэсэг, нам, эвслийн бүлэг, ажлын албаны үйл ажиллагааны ерөнхий зарчим, чиглэлийг тогтооход оршино.

1.2. Энэ дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

1.3. Холбогдох хууль тогтоомж, энэ дүрмийг үндэс болгон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг, Хурлын Тэргүүлэгчид, Хороодын ажиллах журам, ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг батлан, мөрдөж ажиллана.

**Хоёр. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний бүрэн эрх, бүрэлдэхүүн.**

2.1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь /цаашид Хурал гэх/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хурал болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харъяалуулснаас бусад дүүргийн эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх эрх бүхий нутгийн өөрөө удирдах байгууллага мөн.

2.2. Хурал нь нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж, үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.

2.3. Хурал нь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.4. Хурал нь орон нутгийн хурлын сонгуулиар тойргийн оршин суугч, иргэд-сонгогчдын олонхийн саналыг авч, бүрэн эрх нь баталгаажсан, дүүргийн ажил, амьдралын ямар ч асуудлыг Хурлын хуралдаанаар хэлэлцэхэд таслах эрхтэй **Төлөөлөгчдөөс** бүрдэнэ.

2.5. Хурлын Төлөөлөгч бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад сонгогдсон дүүргийн иргэдийн элч төлөөлөгч мөн.

2.6. "Төлөөлөгч" гэж "аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг

2.7. Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн Хурлын тогтоол батлагдснаар эхэлж, орон нутгийн хурлын дараагийн сонгуулиар байгуулагдсан Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол батлагдснаар дуусгавар болно.

2.8. Хурлын Төлөөлөгч "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.9. Хурлын Төлөөлөгч дараах үүрэг, хариуцлага хүлээнэ:

2.9.1. Хурлын хуралдаан, байнгын болон түр хороо, ажлын хэсгийн хуралд хүрэлцэн ирж оролцох.

2.9.2. Хууль, Хурлын дүрэм, хуралдааны дэгийг чанд сахих

2.9.3. Хурлын хуралдаанд үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй, Төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээнд олж авсан байгууллага, хувь хүний нууцад хамаарах асуудлыг нийтийн өмнө дэлгэхгүй байх.

2.9.4. Хурлаас байгуулсан комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллахдаа үүргээ үнэнч шударгаар биелүүлж, ёс зүйг сахих.

2.9.5. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг тогтоосон журмын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв гаргах.

2.10."Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нөхцөл, байдлын улмаас Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

2.11. Хурлын төлөөлөгч нас барсан, чөлөөлөгдсөн эсхүл огцорсон бол тухайн тойрогт нөхөн сонгууль явуулах ба нөхөн сонгогдсон Төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа орон гарсан Төлөөлөгчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

2.12. Хурлын дарга нь орон тооны байх ба түүнийг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлд заасан журмаар сонгоно.

2.13. Хурлын дарга "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.14. Дор дурдсан тохиолдолд Хурлын даргын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно:

2.14.1.нас барсан.

2.14.2.өөр ажилд шилжих болон бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Хурал хүлээн авсан.

2.14.3. хүндээр өвчилсний улмаас цаашид үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан.

2.14.4. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан.

2.15. Хурлын Төлөөлөгч "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны баталгаагаар хангагдахаас гадна дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад саадгүй нэвтэрч, удирдлагын хүмүүстэй нь уулзах, ажилтай нь танилцах, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад аливаа мэдээллийг авах эрхтэй.



2.16. Төлөөлөгчийн Хуралд болон тойрогтоо ажилласан байдал, үйл ажиллагааны үр дүнгээр улирал тутам мөнгөн урамшуулал олгоно. Урамшуулал олгох журмыг хурлын тэргүүлэгчид баталж, хэрэгжилтийг тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга зохион байгуулна.

2.17. Хурлын Төлөөлөгч нас барсан бол түүний ар гэрт 300000 төгрөгийн, Төлөөлөгч хүндээр өвчилсөн, эхнэр /нөхөр/, хүүхэд, төрсөн аав, ээж, хадам эцэг, эх нь нас барсан тохиолдолд 250000 төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлж болно.

2.18. Хурлын төлөөлөгч хүндээр өвчилж, монгол улсад эмчилгээ оношлогоо хийгдэх боломжгүй тохиолдолд эрх бүхий байгууллагын дүгнэлтээр гадаад улсад эмчилгээнд явах шаардлагатай тохиолдолд төлөөлөгчид 5 сая хүртэл төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж болно.

2.19. Хурлын Төлөөлөгч гэр бүл болоход 200000 төгрөгийн, хүүхэдтэй болоход 100000 төгрөгийн тусламж үзүүлж болно.

2.20. Хурлын Төлөөлөгч төрийн дээд цол хүртэж, одон, медалиар шагнуулсан бол 100000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгч болно.

2.21. Хурлын Төлөөлөгчийг дүүргийн Хурлын байгууллагын шугамаар гадаад, дотоодод албан томилолтоор ажиллуулж болно.

2.22. Энэ дүрмийн 2.16-2.21-д заасныг хэрэгжүүлэх зардлыг Хурлын төсвөөс, Тэргүүлэгчдийн шийдвэрээр гаргана.

2.23. Хурал, Тэргүүлэгч, Төлөөлөгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, Хурлын шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

**Гурав. Хурлын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны хэлбэр.**

3.1. Хурал бүрэн эрхээ Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаан байнгын болон түр хороо /ажлын хэсэг/, нам, эвслийн бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

3.2. Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д зааснаар түүний **хуралдаан** байна.

3.3. Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулах ба Төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүйн шаардаснаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус хуралдаан хуралдуулж болно.

3.4. Хурлын хуралдааны үйл ажиллагааг дэгээр зохицуулах бөгөөд дэгийг Хурлын хуралдаанаар хэлэлцэж, тогтоолоор батална.

3.5. Хурлын шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх ба тогтоолыг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхийн саналаар батална.

3.6. Хурлын хуралдааны чөлөө цагт түүний онцгой бүрэн эрхэд хамаарахаас бусад асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах эрх бүхий, Хурлын даргыг оролцуулан 7

хүний бүрэлдэхүүнтэй Хурлын **Тэргүүлэгчид** ажиллах бөгөөд Тэргүүлэгчид асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.7. Хурлын Тэргүүлэгчид Төлөөлөгчдийн дотроос нэр дэвшүүлж, нууцаар санал хурааж, Хурлын бүрэн эрхийн хугацаагаар сонгоно.

3.8. Хурлын Тэргүүлэгчид “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.9. Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга орон тооны байх бөгөөд түүнийг Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж томилно. Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Тэргүүлэгчдийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцоно.

3.10. Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах, Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий **хороодыг** Хурлын хуралдаанаас Хурлын бүрэн эрхийн хугацаагаар байгуулна.

3.11. Хороодын бүрэлдэхүүнийг Хурлын хуралдаанаас батална.

3.12. Хурлын Төлөөлөгч хоёр хүртэл хороонд харъяалагдаж ажиллах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос илээр санал хурааж сонгоно.

3.13. Хороод тус тусын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.13.1. Дүүргийн Засаг даргаас Хуралд өргөн мэдүүлсэн мөрийн хөтөлбөр, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн үндсэн чиглэл, орон нутгийн төсвийн төсөл болон үйл ажиллагааны тайлан, эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт, төсвийн гүйцэтгэлийн талаар санал, дүгнэлт гаргах.

3.13.2. Хурлын хуралдаанаар хэлэлцэх тодорхой асуудлын талаар санал, дүгнэлт гаргах

3.13.3. Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбоотой асуудлаар санал дүгнэлт гаргах

3.13.4. Хурлаас даалгасны дагуу, эсхүл өөрийн санаачлагаар Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, харъяа хэлтэс, албанд шалгаж, ажилтай нь танилцаж, удирдлагын илтгэл мэдээллийг сонсож, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх.

3.14. Хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.15. Хорооны хуралдааныг хорооны даргын шийдвэрээр зарлан хуралдуулж, гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.16. Хороо жилд 1-ээс доошгүй удаа Хуралд ажлынхаа тайланг тавина.

3.17. Хурал нь цаг үеийн асуудлыг судлах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх үүрэг бүхий **түр хороо, ажлын хэсэг** байгуулан ажиллуулж болно.

3.18. Түр хороо, ажлын хэсгийн ажлын чиглэл, удирдамжийг Хурлын даргаар батлуулж, ажлын гүйцэтгэл, тайланг Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулна.

3.19. Хуралд 3-аас доошгүй суудал авсан **нам, эвсэл бүлэг** байгуулж болох бөгөөд нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийг Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

3.20. Нам, эвслийн бүлэг хурлаар хэлэлцэх асуудлаар судалгаа шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах, ажлын хэсэг байгуулж болно.

3.21. Хурлын дарга нам, эвслийн бүлгийг Хурлын хуралдаанд танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

3.22. Шинээр нөхөн сонгогдсон Төлөөлөгч аль нэг намын бүлэгт нэгдэн орвол түүнийг Хурлын хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.

3.23. Нам, эвслийн бүлэг Хурлын хуралдаанаас завсарлага авах журмыг Хурлын хуралдааны дэгээр зохицуулна.

3.24. Хурал дахь нам, эвслийн бүлэг нь дотоод зохион байгуулалтаа өөрсдөө шийдвэрлэнэ.

3.25. Хурал дахь нам, эвслийн бүлэг ажлын алба /ажилтан/-тай байх бөгөөд түүний ажиллах журам, орон тоо, зардлыг Хурлын Тэргүүлэгчид батална. Нам, эвслийн бүлэг ажлын байр, ажиллах нөхцлөөр хангагдана.

**Дөрөв. Хурлын ажлын алба.**

4.1. Хурлын үйл ажиллагааг төрийн албаны стандартын дагуу зохион байгуулж Хурал, Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Хурал, Тэргүүлэгчид, байнгын болон түр хороо, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба ажиллана.

4.2. Ажлын албыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга толгойлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

4.3. Ажлын албаны орон тоо, цалингийн сан, ажилтнуудын ажил үүргийн хуваарийг Хурлын Тэргүүлэгчид, ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтыг Хурлын дарга батална.

4.4. Хурлын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд төрийн захиргааны албан хаагчид ажиллах бөгөөд тэдний эрх зүйн байдлыг "Төрийн албаны тухай" хуулиар зохицуулна.

4.5. Хурлын ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг Хурлын Тэргүүлэгчид батална.

4.6. Хурлын ажлын алба нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дүүргийн Засаг даргын Тамгын газартай нягт хамтран ажиллана.

**Тав. Бусад зүйл.**

5.1. Хурал нь бие даасан хуулийн этгээд бөгөөд "Улсын бүртгэлийн тухай" хуулийн 17 дугаар зүйлд заасан журмаар бүртгүүлж, Улсын бүртгэлийн гэрчилгээ авна.

5.2. Хурал тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Хурлын хороо, ажлын алба Хурлын албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгийг ашиглана. Хурал дахь нам эвслийн бүлэг өөрийн тэмдэгтэй байж болно. Хурлын төлөөлөгчийн гарын үсэг бүхий албан бичигт нам эвслийн болон хурлын тэмдэг дарж баталгаажуулна.

5.3. Хурлын бичиг хэргийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, архивын үндсэн зааврын дагуу хөтөлж, Хурал, Тэргүүлэгчдийн хуралдааны материалыг хуралдаан тус бүрээр хадгаламжийн нэгж үүсгэж, дараа оны 1 дүгээр улиралд багтаан дүүргийн архивт шилжүүлнэ.

5.4. Хурал өөрийн төсөвтэй, банкинд харилцах данстай, эд хөрөнгөтэй байна.

5.5. "Төсвийн тухай хууль"-ийн 14.1.15-д заасны дагуу Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга төсвийн ерөнхийлөн захирагч байна.

5.6. "Төсвийн тухай хууль"-ийн 16.4.14-т заасны дагуу дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн шууд захирагч байна.

5.7. Хурал өөрийн шагналтай байх ба шагналын төрөл, олгох журмыг Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

5.8. Хурал дэргэдээ улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг удирдаж зохион байгуулах зөвлөл зэрэг хууль тогтоомжид заасан орон тооны бус нэгжийг ажиллуулахаас гадна өөрийн санаачлагаар бусад комисс, зөвлөл ажиллуулж болно.

195/15



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын ажлын албаны ажилтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**Нийслэлийн Чингэлтэй дүүргийн  
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны дэг**

**1 дүгээр зүйл. Дэгийн зорилт**

1.1. Энэхүү дэгийн зорилт нь Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон түүний хороо, түр хороодын хуралдаан, ажлын хэсгүүдийн /Цаашид хуралдаан гэх/-ыг зохион байгуулах, хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах дэг, журамтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Нийтлэг үндэслэл**

2.1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан мөн.  
2.2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн үйл ажиллагааг тухайн хуралдааны дэгээр зохицуулна.

**3 дугаар зүйл. Хуралдааны үндсэн зарчим**

3.1. Хуралдаан хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.  
3.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /цаашид "Хурлын төлөөлөгч" гэх/ хуралдааныг товлон зарласан цагт хүрэлцэн ирэх, хуралд идэвхитэй оролцох үүрэгтэй.

**4 дүгээр зүйл. Хурлын тов, ирц**

4.1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /цаашид "Хурал" гэх/ ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, ээлжит бус хуралдааныг төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хуралдуулна.  
4.2. Хурал дахь нам, эвсэлийн бүлэг нь ээлжит бус хуралдааныг хуралдуулах саналыг хурлын тэргүүлэгчдэд санал болгож болох бөгөөд тэргүүлэгчид хуралдаж шийдвэрлэнэ.  
4.3. Хурлын анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй хурлын Тэргүүлэгчид хуралдаан эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна.  
4.4. Чингэлтэй дүүргийн Хурлын анхдугаар болон ээлжит /ээлжит бус/ хуралдаанд тухайн хурлын нийт төлөөлөгчийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.  
4.5. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.  
4.6. Төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүйд хүрвэл Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад мэдэгдэж хэлэлцэх

асуудалтай холбоотой саналаа урьдчилан бичгээр ирүүлж болно. Төлөөлөгч хуралдаанаас гарсан шийдвэртэй танилцаж болно.

**5 дугаар зүйл. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан**

5.1. Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь нээж удирдах бөгөөд дараахь асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- ДИТХ-ын ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай, дүүргийн сонгуулийн хорооны даргын илтгэл
- ДИТХ-ын дэгийг хэлэлцэж батлах
- ДИТХ-ын даргыг батлах
- ДИТХ-ын Тэргүүлэгчдийн сонгох
- Дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх

5.2. ДИТХ-ын ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай, дүүргийн сонгуулийн хорооны дарга илтгэл тавих бөгөөд илтгэлтэй холбогдуулан асуулт, хариулт явуулна.

5.3. Асуулт, хариулт дууссаны дараа төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тогтоолыг батлана.

5.4. Хурлын даргад нэр дэвшүүлэхдээ сонгуулийн дүнгээр тухайн Хуралд хамгийн олон суудал авсан нам, эвсэл эхэлж нэр дэвшүүлэх эрхтэй. Мөн тухайн Хурлын төлөөлөгчид Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчдийн нэрийг дэвшүүлж болно.

5.5. Хурлын даргад нэг хүн нэр дэвшсэн бол илээр, хоёр ба түүнээс дээш хүний нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан төлөөлөгчийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгогдсонд тооцож, тамга тэмдгийг гардуулна.

5.6. Хурлын даргад нэр дэвшсэн нэр дэвшигчдийн хэн ч олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан хоёр төлөөлөгчийг хоёр дахь санал хураалтанд оруулна. Тэдгээрийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол Хурлын даргад дахин нэр дэвшүүлэх ажиллагааг явуулна.

5.7. Хурлын төлөөлөгчид санал хураалтанд оролцож зөвхөн нэг хүний төлөө санал өгөх ба нэр дэвшигч өөрөө санал хураалтанд оролцох эрхтэй.

5.8. Хурлын дарга болон Хурлын Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх санал хураалтыг зохион байгуулах Тооллогын комиссыг Төлөөлөгчдийн саналаар байгуулж болно.

5.9. Хурлын Тэргүүлэгчдийг Хурлын даргыг оролцуулан 5-7 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

5.10. Чингэлтэй дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлэх эрхтэй. Дүүргийн Засаг даргад нэр дэвшигч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.5-д заасан шаардлагыг хангасан байна.

5.11. Чингэлтэй дүүргийн Засаг даргад нэг хүний нэр дэвшсэн бол илээр, хоёр болон түүнээс дээш хүн нэр дэвшсэн бол нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон

төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчдийг томилуулахаар Нийслэлийн Засаг даргад уламжилна.

**6 дугаар зүйл. Хурлын хуралдаанд асуудал оруулах эрх**

6.1. Хурлын Тэргүүлэгчид, хороо, ажлын хэсэг түүнчлэн төлөөлөгч, тухайн нэгжийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

6.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн дүүргийн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. Хуралдаанаар хэлэлцүүлэх хэлэлцэх асуудлыг Хурлын даргад өргөн барьж, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн, хэлэлцэх асуудлыг төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах боломжгүй бол энэ тухайгаа хариу мэдэгдэнэ.

**7 дугаар зүйл. Нам эвслийн бүлэг байгуулах, түүний ажлын зохион байгуулалт**

7.1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 3-аас доошгүй суудал авсан нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг анхдугаар хуралдааны даргад өргөн мэдүүлнэ.

7.2. Анхдугаар хуралдааны дарга нам, эвслийн бүлгийг танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

7.3. Шинээр нөхөн сонгогдсон төлөөлөгч аль нэг намын бүлэгт нэгдэн орвол түүнийг албан ёсоор мэдээлнэ.

7.4. Нам, эвслийн бүлэг нь хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор санал дүгнэлтээ гаргах, ажлын хэсэг байгуулах, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, ажлын хорооны хурлын үед болон нэгдсэн хуралдааны үед завсарлага авах, Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх асуудалд санал оруулах эрхтэй.

7.5. Нам, эвслийн бүлэг нь ажлын албатай байх бөгөөд бүлгийн ажлын албаны ажиллах журам, орон тоо, зардлыг тэргүүлэгчид батлана.

7.6. Шаардлагатай гэж үзсэн Хурлын шийдвэрийн төслийг нам, эвслийн бүлэг хэлэлцэж, гаргасан дүгнэлтээ Хурлын хуралдаанд танилцуулна.

**8 дугаар зүйл. Хурлын хороо болон дэд хороо, түр хороодыг байгуулах, тэдгээрийн даргыг сонгох**

8.1. Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, чиг үүрэг бүхий хороог байгуулан ажиллуулна. Тухайн хороонд хамаарах асуудлаар дэд хороо байгуулж болно.

8.2. Хороог Хурлын бүрэн эрхийн хугацаагаар төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах бөгөөд Хорооны даргыг тухайн хорооны төлөөлөгчдийн дотроос сонгоно.

8.3. Хурлаас цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

**9 дүгээр зүйл. Хуралдааны шийдвэр**

9.1. Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар батлана.

9.2. Хурлын тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.



**10 дугаар зүйл. Хурлын шийдвэрт хориг тавих**

10.1. Хурал үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

10.2. Хоригийг тухайн шийдвэр батлагдсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан бичгээр тавих бөгөөд хориг тавих болсон үндэслэлийг тодорхой заана.

10.3. Хоригийг хүлээж авсанаас хойш 15 хоногийн дотор хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнийг нийт төлөөлөгчдийн олонхи нь хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн шийдвэр, тэдгээрийн холбогдох хэсгийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

10.4. Хурлын шийдвэрт бүхэлд нь хориг тавьсан бол үйлчлэлийг бүрэн хэмжээгээр, хэсэгчлэн тавьсан бол холбогдох зүйл, заалтын үйлчлэлийг Хурлын дарга хүлээн авснаас хойш хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд түдгэлзсэнд тооцно.

10.5. Засаг даргыг чөлөөлөх, огцруулах асуудлаар гаргасан тухайн хурлын шийдвэрт Засаг дарга хориг тавих эрхгүй.

10.6. Тавьсан хоригийг нь Хурал өөрөө төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих, дээд шатны байгууллагад гаргаж болно.

**11 дүгээр зүйл. Хурлын хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах журам**

11.1. Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хуулинд хэлэлцэхээр заасан асуудал, Хурлын байгууллагаас сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл, Хурал, Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

11.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан илтгэл, гаргах шийдвэрийн төслийг асуудал оруулж байгаа Хурлын Тэргүүлэгчид, хороо, ажлын хэсэг, төлөөлөгч болон Хурлын ажлын алба, Засаг дарга түүний Тамгын газар боловсруулна.

11.3. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг шаардлагатай тохиолдолд тухайн асуудал эрхэлсэн хорооны хурлаар урьдчилан хэлэлцэж, нэгдсэн санал дүгнэлтийг хуралдаанд оруулна.

11.4. Хурлын хуралдаанаар хэлэлцэх илтгэл, мэдээллийг Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан болон засаг даргын зөвлөлийн хурлаар урьдчилан хэлэлцэнэ.

11.5. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлан судалгаа, дүгнэлт гаргах, иргэдийн саналыг авах зорилгоор хэвлэл мэдээлийн хэрэгслэлээр сурталчилах, хуралдааныг бэлтгэх ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.

11.6. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд холбогдох тооцоо судалгаа, лавлагаа, гаргах шийдвэрийн төслийг хавсаргаж хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Хурлын Төлөөлөгчдөд тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

11.7. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд урилгаар оролцох албан тушаалтны нэрсийг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн урилгыг Хурлын ажлын албанаас хуралдаан болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ. Урилгаар оролцогсод нь хуралдааны дотоод

журам, дэгийг биелүүлж, хуралдаанд оролцох урилгаа үзүүлж бүртгүүлэн хуралд оролцоно.

11.8. Хуралдааныг хэвийн явуулах байр бэлтгэх, хүндэтгэлийн туг, сүлд болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар урьдчилан хангасан байна.

301 51



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН  
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**2013 оны төсөв батлах тухай**

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 1, 18 дугаар зүйлийн 1.2-ын "б", " Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 3, 50 дугаар зүйлийн 1-ийн 2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. 2013 оны дүүргийн орон нутгийн төсвийн орлогын нийт дүнг 17 тэрбум 100 сая 226.6 мянган төгрөгөөр тогтоож, орлогын нэр төрлийн хэмжээг доор дурьдсанаар баталсугай

	/мянган төгрөгөөр/	
<b>1. Нийт орлого</b>	<b>17.100.226,6</b>	
<b>А. Татварын орлого</b>	<b>14.950.900,0</b>	
<b>1. Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>2.745.000,0</b>	
1.1 Аж ахуй эрхлэсний орлого. иргэн	1.710.000,0	
1.2 Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	800.000,0	
1.3 Орлогыг тодорхойлох боломжгүй иргэдийн орлого /патент/	55.000,0	
1.4 Жишгээр ногдуулсан татвар	80.000,0	
1.5 Иргэдийн хадгаламжийн хүүгийн Орлогын албан татвар	100.000,0	
<b>2 Өмчийн албан татвар</b>	<b>5.900,0</b>	
2.1 Бууны татвар	5.900,0	
<b>3. Бусад татвар</b>	<b>11.600.000,0</b>	
3.1 Улсын тэмдэгтийн хураамж	11.600.000,0	
<b>4. Хөрөнгийн орлого</b>	<b>600.000,0</b>	
4.1 Үл хөдлөх эд Хөрөнгө борлуулсаны орлого	600.000,0	

2150010092

1012

<b>Б. Татварын бус орлого</b>	<b>2.149326.6</b>
1. Татварын хүүгийн орлого	180.000,0
2. Татварын торгуулийн орлого	580.000,0
3. Татварын алдангийн орлого	190.000,0
4. Хог хаягдалын хураамж	1.150.000,0
5. Өөрийн орлого	49326,6

Хоёр. 2013 оны дүүргийн төсвийн зарлагын нийт дүнг **17** тэрбум **100** сая **226,6** мянган төгрөгөөр тогтоож дор дурьдсанаар баталсугай.

	/мянган төгрөгөөр/
<b>Дүүргийн төсвийн нийт зарлага</b>	<b>17.100.226,6</b>
1. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.660.018,1
2. Засаг даргын Тамгын газар	2.239.095,1
3. Орон нутгийн нөөц сан	399.223,6
4. Нийтийн аж ахуй зам талбай, ариутгал, Хог хаягдал устгах, хог тээвэр цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2.325.184,9
5. Гудамжны гэрэлтүүлгийн арчилгаа, засварын зардал	284.037,8
6. Татварын байцаагчийн урамшуулал	60.000,0
7. Ахмадын хороо	41683,3
8. Бизнес инкубатор төв	264.802,6
9. Худалдан авах ажиллагааны нэгж	83.744,8
10. Нийгмийн халамжийн сан	9.742.436,4

Гурав. Улсын төсвийн тусгай шилжүүлгийн санхүүжилтийг **24** тэрбум **17** сая **205,2** мянган төгрөгөөр тогтоож дор дурьдсанаар баталсугай.

1. Ерөнхий боловсролын сургууль	14.760.526,47
2. Сургуулийн өмнөх боловсрол	7.427.776,792
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт	1.647.311,87
4. Биеийн тамир спорт хороо	181.590,0
5.	

Дөрөв. Орон нутгийн хөгжлийн санд Нийслэлийн хөгжлийн сангаас хуваарилагдан ирэх шилжүүлгийн хэмжээг **2** тэрбум **832** сая **669** мянган төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  ДЭБЭТ-ЭРДЭНЭ



53  
203



# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

## Дүүргийн 2013 оны нийгэм, эдийн засгийн зорилт батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2а заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2013 оны нийгэм, эдийн засгийн зорилтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Дүүргийн 2013 оны нийгэм, эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг дүүргийн Засаг даргад даалгасугай.
3. Дүүргийн 2013 оны нийгэм, эдийн засгийн зорилтын биелэлтэнд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

*[Handwritten signature]*

Д.БАТ-ЭРДЭНЭ

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2013 ОНЫ ЗОРИЛТ

2013 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Тайлбар	Хариуцах байгууллага
<b>НЭГ. ХҮНЛЭГ ОРЧИН-НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>		
<b>1.1. Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир</b>		
Иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох замаар хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулна.	Нийслэл зорилт	
"Эрүүл хот, дүүрэг, ажлын байр, сургууль бий болгох дэд хөтөлбөр"-үүдийг хэрэгжүүлнэ.		
Яаралтай түргэн тусламжийн пунктыг барьж ашиглалтад оруулна.	Нийслэл зорилт	
Өрхийн эрүүл мэндийн төвийг байртай болгох ажлыг үргэлжлүүлэн, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжөөр хангана. • 1, 3, 5, 14-р хороонд Хорооны цогцолбор барина.	Нийслэл	
Өрхийн эмч нарын үйл ажиллагааг ажлын чанар, үр дүнгийн индексээр хэмжин урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.	Нийслэл зорилт	
Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.		
Нийслэлийн эрүүл мэндийн салбарын харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтаар ажиллуулах ажлыг эхлүүлнэ.		
Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгон, "Цахим эрүүл мэнд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ		
Байгууллагын вэб сайтаар иргэдэд зориулсан "Эрүүл мэндийн зөвлөгөө булан" гарган үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллуулах		
Эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, эх нялхсын эндэгдлийн бууруулна.		
Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх орчинг бүрдүүлэн, хороо бүрт дугуйгаар явах, алхах, гүйх зам, талбайг үргэлжлүүлэн байгуулна.		
Дүүргийн усан бассейн бүхий 1000 хүний суудалтай Спорт цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.	Нийслэл зорилт	
23 дугаар сургуулийн дэргэд барьж буй мөсөн гулгуурын байгууламжийг үргэлжлүүлэн барьж дуусгана.		
Чингэлтэйн Салхит, Ар согоотын зуслангийн бүсэд Өвлийн спортын цогцолбор, цанын бааз байгуулах ажлыг эхлүүлнэ.		
<b>1.2. Боловсрол, соёл</b>		
Боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, сургууль цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлнэ. • 49, 50, 57, 72-р сургууль, 33, 39, 56, 70, 74, 103, 124-р цэцэрлэгийн ариун цэврийн өрөөг тохижуулна. • Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		
Шинээр байгуулагдсан сургууль, цэцэрлэгүүдийг шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.		
Төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин, хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлнэ.		
Дүүргийн 8, 11, 16, 18-р хороонд цэцэрлэгийн барилга шинээр барина.	Нийслэлийн зорилт	
Дүүргийн 5 дугаар цэцэрлэгийн дэргэд 240 хүүхдийн ортой цэцэрлэг байгуулна.	Нийслэлийн зорилт	

10/11

4, 5, 18 дугаар цэцэрлэгийн барилгыг буулган, шинээр 200 хүүхдийн ортой цээцрлэг барина.		
19, 39, 70, 74, 108 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих		
Алслагдсан гэр хороололд иргэд, аж ахуйн нэгжүүдээс хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн салбар бүлэг байгуулахыг дэмжинэ.		
24, 57 дугаар сургуулиудад өргөтгөлийн барилга барих		
“Цахим сургууль” болох ажлыг үргэлжлүүлэх, өндөр хурдны интернетэд холбох талаар шат шатны байгууллагатай хамтран ажиллах		
“Цахим цэцэрлэг” хөтөлбөрийн хүрээнд багш хөгжлийн цахим төвтэй болгох, өндөр хурдны интернетэд холбох		
Сургуулиудын мэдээлэл зүйн кабинетийг шинээр байгуулах, сургууль, цэцэрлэгийн хэрэглээний компьютерийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх		
Мэргэжил боловсролгүй, сургууль завсардагч, хүүхэд залуусын судалгааг нарийвчлан гаргаж, тэдэнд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулна.		
“Гэгээрэл хөгжил төв”-ийн байрыг шинэчлэн барих, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах		
Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.		
Монгол уламжлал, ёс заншлаа дээдэлсэн зөв хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.		
Төвийн дулааны нэгдсэн шугам сүлжээнээс алслагдсан гэр хороодын сургууль, цэцэрлэг, байр, айл өрхүүдийн дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон технологийн шинэчилсэн зуухаар шийдвэрлэнэ.	Нийслэлийн зорилт	
<ul style="list-style-type: none"> <li>• 33, 37, 39, 70, 108 дугаар цэцэрлэг</li> <li>• 23 дугаар сургуулийн гадна талбайг тохижуулах</li> </ul>		
Сургууль, цэцэрлэгийн орчинд хурд сааруулагч байрлуулж, замын тэмдэг тэмдэглэгээг тавина.	Нийслэлийн зорилт	
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын цүнхийг гэрэл цацруулагчтай болгох ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Хөдөлгөөний аюулгүй байдал нь хангагдаагүй сургуулийн орчинг сайжруулах арга хэмжээ авна.	Нийслэлийн зорилт	
Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт семинар, уралдаан тэмцээн, туршлага судлуулах ажлыг зохион байгуулна.		
Дүүргийн багш нарын “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж ёс зүй, эерэг хандлагыг дэлгэрүүлэн боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлж, шинэ санал санаачилгыг дэмжин ажиллана.		
Дүүрэгт Соёлын төв байгуулах ажлыг эхлүүлэх		
Суурин соёл иргэншилд дасан зохицсон нийслэл хотын иргэнийг төлөвшүүлэхэд чиглэсэн “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.		
Дүүргийн нутаг дэвсгэр дэх соёлын өв, үл хөдлөх дурсгалт газар, хөшөө дурсгалыг хамгаалах, сурталчлах олон талт ажлыг зохион байгуулна.		
МУ-ын Засгийн газрын Соёл урлагийн чиглэлээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, урлаг соёлын төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулна.		
“Хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэе” аян өрнүүлнэ.		
1. Бүх сургуулиудийн бага ангийн сурагчдын дунд шатрын дугуйланг тусгай хөтөлбөрийн дагуу хичээллүүлнэ.		
Дүүрэгт хөдөлгөөнт болон цахим номын сан байгуулна.		
<b>1.3. Хөдөлмөр эрхлэлт</b>		
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хороо бүрт цахим бирж ажиллуулна.	Нийслэл зорилт	
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээг хүн амын зорилтот бүлгүүдийн онцлогт нийцсэн шинэлэг хэлбэрээр үзүүлнэ.	Нийслэл зорилт	
Ажил идэвхтэй хайж бүртгэгдсэн иргэдийг ажилд зуучлан 2,5 мянган хүнийг байнгын ажлын байраар хангана.	Нийслэл зорилт	

Нийтийг хамарсан мэргэжил шаардахгүй ажилд ажилгүй 5.0 гаруй иргэдийг хамруулан, түр ажлын байраар хангана.	Нийслэл зорилт
"Оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн 10.0 мянган оюутан залуучуудыг цагийн ажлын байраар хангана.	Нийслэл зорилт
Гэр хорооллыг дахин төлөвлөлт хийх замаар тохилог орон сууцны хороолол болгон хөгжүүлж амьдран буй орчноо тохижуулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.	Нийслэл зорилт
Ажил, мэргэжилгүй 12.0 мянган иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтанд хамруулж, мэргэжил эзэмшүүлэн 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангана.	
Аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан ажлын байран дах сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэн ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.	
Хувьараа болон хоршиж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэл санаачилгатай иргэдэд мэргэжил өргө зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэх сургалтанд хамруулах	
Хувьараа болон хоршиж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэл санаачилгатай иргэдийн төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан", "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан"-гаас зээл олгох	
"Бизнес инкубатор төв" –Д бизнес эрхлэгч иргэдэд шинэ жижиг бизнес төвөгтэй эмзэг болон төвөгтэй эхний үе шатуудыг даван туулах, цаашлаад өсөлтөнд хүрэх хүртэл бойжуулан зах зээлд өрсөлдөх чадвартай болгож гаргах бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлэх	
Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.	
Нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах, дэд бүтцийг засварлах зэрэг бүтээн байгуулалтанд чиглэгдсэн ажилд нийгмийн эмзэг бүлгийнхэн болон орлогогүй 15.0 мянга хүртэлх иргэнийг хамруулж түр ажлын байраар хангана.	
<b>1.4. Нийгмийн халамжийн үйлчилгээ</b>	
Нийгмийн халамжаас хамааралтай өрхийн тоог бууруулж, "Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар гэр бүл төвтэй бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.	
Нийгмийн халамжийн дэмжлэг туслацаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтыг түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээ бий болгоно.	
Зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.	
Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэгдсэн барилга байгууламж, амралт, үйлчилгээний газруудыг нэмэгдүүлэн, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.	Нийслэлийн зорилт
Хороодод гэр бүл, хүүхэд хөгжлийн төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдөр өнжүүлэх, нөхөн сэргээх төвийг байгуулна.	Нийслэлийн зорилт
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх багш нарыг үе шаттай бэлтгэнэ.	Нийслэлийн зорилт
<b>ХОЁР. Хоёр. НЭЭЛТЭЙ ОРЧИН-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ</b>	
<b>2.1. Эдийн засгийн хөгжил</b>	
Дүүргийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх тодорхой ажлуудыг зохион байгуулна.	
Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийж, дотоод хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулж, өр авлага үүсгэхгүй байх	
Хуулиар зөвшөөрөгдсөн мэдээлэл, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, тендерийн тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах ажлыг тогтмол хийх	
Аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийн нэгдсэн сантай болох, Нэг цэгийн үйлчилгээний чанарт ахиц гаргах	
Төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүнг иргэдэд эргэн тайлагнах хэлбэрийг төлөвшүүлнэ.	Нийслэлийн зорилт
Хөрөнгө оруулалтын хяналт хариуцлагыг нэмэгдүүлэхэд төрийн бус байгууллага иргэдийн оролцоог хангана	Нийслэлийн зорилт



	зорилт	
2013 онд Улс, нийслэл, дүүргийн төсвөөс санхүүжигдэх барилга, байгууламжуудыг барьж ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулж, дүүргийн өмч хөрөнгийг нэмэгдүүлэх		
Аж ахуйн нэгж, иргэдэд ахуйн үйлчилгээний зориулалтаар гэрээгээр эзэмшүүлсэн нийслэлийн өмчийн барилга объектуудыг тухайн үйлчилгээний чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх		
Орон нутгийн өмч хөрөнгийн эзэмшилт, арчилгаа, хамгаалалтыг санаачилгатай ажиллах		
Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээр "Дотоод мэдээлэл", "Статистикийн эмхэтгэл"-ийг сар, улирал, жилээр гарган, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах		
Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах нөхцөлийг бүрдүүлэн, заавал даатгуулагч болон ажил олгогчийг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 101,0-ээс доошгүй хувиар биелүүлэх		
Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай МУ-ын хуулийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулна.		
МУ-ын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу Эрүүл мэндийн даатгалд хамрагдан, 3 жил дараалан тус сангаас эмчилгээ үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчдад 1 удаа эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах заалтыг хэрэгжүүлнэ.		
Тэтгэвэр, тэтгэмж олголт, ажил олгогч байгууллагын нийгмийн даатгалын тайланг цахим хэлбэрээр авах, даатгуулагчдад цахим мэдээлэл хүргэх ажлыг үргэлжлүүлнэ.		
2013 онд цалин, тэтгэврийн зардалд нэмж шаардагдах эх үүсвэрийг нийгмийн даатгалын санд хуримтлуулах арга хэмжээ авах		
<b>3.2. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх</b>		
Дүүргийн хүн амын мэдээллийн санг түшиглэн татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг боловсронгуй болгох		
Дүүргийн нутаг дэвсгэрт үл хөдлөх хөрөнгөтэй, байршилтай мөртлөө өөр дүүрэгтэй харьцдаг аж ахуй нэгж, байгууллагуудыг зурагжуулах		
Татварын өрийн барагдуулалтыг стандартад хүргэх, татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх замаар төсвийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр тогтмол ханган биелүүлэх		
Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, татвараас зайлсхийх, хууль зөрчих явдлыг таслан зогсооход чиглэсэн ажлууд зохион байгуулах		
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх, замын сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах		
<b>2.3. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ</b>		
Иргэдийн хөдөлмөрлөх эрхийг ханган "Бүтээмжтэй ажлын байр", "Хамтдаа хөгжье" хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.		
Жижиг, дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах "Чингэлтэйд үйлдвэрлэв" сүлжээ, цэгийг бий болгоно.		
Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд банкны урт хугацааны, барьцаа шаардахгүй зээл олгоход бүх талын дэмжлэг үзүүлэн, "Дүүргийн эрсдэлийн сан" байгуулан ажиллана.		
ЖДҮ-ийн санхүүжилт олгох журмыг шинэчилж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг урт хугацааны хөнгөлөлттэй зээлэнд хамруулна.	Нийслэлийн зорилт	
Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэх мэдээллийн сүлжээг боловсронгуй болгоно.	Нийслэлийн зорилт	
ЖДҮ-ийн төвүүдэд бизнесийн болон үйлдвэрлэл, технологийн сургалтын модуль боловсруулан, бойжигчдын тоог нэмэгдүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Өрхийн болон хувиараа жижиг, бичил бизнес эрхлэх иргэдэд бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Ажил олгогч болон ажил хайгчийн хөдөлмөр зуучлалын "Чингэлтэйн онлайн" сүлжээг нэвтрүүлнэ.		
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "Иргэдийн хөгжлийн төв" байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.		
Жижиг, дунд, өрхийн үйлдвэрийн "Чингэлтэйн брэнд бүтээгдэхүүн" төсөл хэрэгжүүлэн, гадаад дотоодын зах зээлд сурталчлах ажлыг зохион байгуулна.		
Гэр хороололд худалдаа, ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэдийн хөрөнгө оруулалтын төсөл, санал		

2013

санаачилгыг дэмжин ажиллана.		
<b>2.3. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ</b>		
Газар тариалангийн аймгуудтай гэрээ байгуулах замаар дүүргийн иргэдэд чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлнэ.		
Бүлгийн зохион байгуулалтайгаар газар тариалан эрхлэх төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдийн санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.		
Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан журам боловсруулан мөрдүүлж, хяналтын байгууллагын хяналтын үр нөлөөг сайжруулна.		
Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, архи тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.		
Архи, тамхины болон эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах бүх нийтийн аян өрнүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Согтууруулах ундаа, тамхины үйлдвэрлэл; худалдаа, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, дүнг үндэслэн холбогдох арга хэмжээг авна.	Нийслэлийн зорилт	
Залуучуудад зориулсан "архигүй" цэнгээний жишиг газрыг дүүрэг бүрт бий болгох ажлыг хэрэгжүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Тэмдэглэлт өдөр, баяр ёслолын аливаа арга хэмжээнд төсвийн мөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг зогсооно.	Нийслэлийн зорилт	
<i>Мэргэжлийн хяналтын байгууллагуудын хяналтын үр нөлөөг сайжруулна.</i>		
<i>"Малын эрүүл мэнд" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.</i>		
<b>Гурав. ТОХИЛОГ ОРЧИН-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ</b>		
<b>3.1. ХОТ ТОХИЖИЛТ</b>		
Улаанбаатар хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөлтэй уялдуулан иргэдийн оролцоотойгоор дүүргийн хот байгуулалтын төлөвлөлтийг хэсэгчилсэн байдлаар шинэчлэн боловсруулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• "Төвийн бүсийн төлөвлөлт" буюу 1-6 дугаар хороог дахин төлөвлөх хөтөлбөр хэрэгжүүлнэ.</li> <li>• "Гэр хорооллыг барилгажуулах төлөвлөлт" буюу 7-10 дугаар хороог орон сууцны хороолол болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.</li> <li>• "Шинэ суурин төлөвлөлт" буюу Хайлааст, Чингэлтэйн аманд хувийн орон барих "Нэг өрх-Нэг орон сууц" загвар төслийг хэрэгжүүлнэ.</li> <li>• "Ногоон бүсийн төлөвлөлт" буюу зуслангуудад дэд бүтэц, амины орон сууц барих төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.</li> </ul>		
Дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороололд хэсэгчилсэн хангамжтай болох иргэдийн санал санаачлагыг дэмжинэ.	Нийслэлийн зорилт	
Дахин төлөвлөлт хийгдсэн гэр хорооллын инженерийн дэд бүтцийг бий болгох ажлыг эхлүүлнэ. Чингэлтэй 8, 9, 10, 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Дэнжийн-1000 хорооллын усан хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээний ажлыг хийнэ.	Нийслэлийн зорилт	
Дахин төлөвлөлт хийгдэж өөрсдийн хөрөнгөөр инженерийн нэгдсэн дэд бүтэцтэй болсон иргэд, аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийн тодорхой хувийг нөхөн олгох эрх зүйн орчин бий болгоно.	Нийслэлийн зорилт	
Дахин төлөвлөлтөө өөрсдөө хийн ажиллаж байгаа иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжинэ.	Нийслэлийн зорилт	
Чингэлтэй дүүрэг 10 дугаар хороо 150х2 айлын орон сууцтүрээсийн орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлыг хийнэ.	Нийслэлийн зорилт	
"Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн дагуу орон сууцжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.	Нийслэлийн зорилт	
Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугамд бүрэн холбож, орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.		
Эрчим хүчний хэмнэлттэй, ердийн халаалтын зуухыг гэр хорооллын 25 0 мянган өрхөд нийлүүлнэ.	Нийслэл зорилт	

1000

Байгууллага, иргэд өөрийн хөрөнгөөр утааны шүүлтүүр болон утаа бууруулах зориулалттай тоног төхөөрөмж суурилуулсан тохиолдолд Цэвэр агаарын хангаас зардлыг нөхөж өгөх ажлыг зохион байгуулна.	Нийслэл зорилт	
Боловсруулсан түлшний үйлдвэрлэлд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Боловсруулсан түлшний хэрэглээг 30-50%-иар нэмэгдүүлнэ.	Нийслэл зорилт	
Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсийн 2.0 мянгаас доошгүй айл, өрхийг утаа шүүгчээр хангана.	Нийслэл зорилт	
Гэр хорооллын шаардлагатай газруудад явган хүний гүүрийг үргэлжлүүлэн барина.		
Гэр хороололд худалдаа ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдийг байгуулж, үйлчилгээний стандартыг мөрдүүлнэ.		
<b>3.2. Газрын харилцаа</b>		
Газрыг иргэдэд эзэмшүүлэх, өмчлүүлэх болон иргэд газраа эдийн засгийн эргэлтэнд оруулахыг тууштай дэмжинэ.		
Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар айл, өрхүүдийг төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэрт хэсэгчлэн холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		
"Гэр хорооллын хөгжлийн стратеги" төслийн хүрээнд алслагдсан гэр хороолол Дэнжийн мянга, Чингэлтэй, Хайлаастанд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх		
Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах явцад судалгааг гаргаж бэлтгэл ажлыг хангах, 10-р хорооны нутаг дэвсгэрт Эрдэнэ суврага ХХК-ны хашаанд дамжин өнгөрүүлэх орон сууцны барилгын ажил эхлүүлэх		
Зуслангийн болон шинэ суурьшлын бүсүүдэд хөрсийг бохирдлоос хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, бие даасан инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бий болгох ажлыг эхлүүлнэ.		
Зуслангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг дахин батлуулах, тодотгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуула		
Дүүргийн ногоон бүсэд зуслангийн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэдэд газар өмчлүүлэх бэлтгэл ажлыг хангаж өмчлүүлэх ажлыг эхлүүлэх		
Нийслэлийн зуслангийн бүсийн байгаль орчныг хамгаалах, энэ бүсэд дахин төлөвлөлт хийх замаар ая тухтай, цэвэр агаар бүхий ногоон суурьшлын бүс болгон хөгжүүлнэ.		
Тус дүүргийн засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 18-ны өдөрийн А/246 дугаар захирамжаар газар эзэмшүүлэх ашиглуулах харилцаанд хяналт тавих, эмх замбараагүй олгогдсон газар олголтыг цэгцлэх зорилгоор ойн зурвас, зуслангийн ногоон бүс бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтооно.		
Туул, Сэлбэ, Дунд голын усны урсацыг нэмэгдүүлэх, сэргээх, гадаргын усыг хуримтлуулах усан сан, цөөрөм байгуулж, хот орчмын голын ай сав газар, гол, булаг, шандыг хамгаалж, ногоон байгууламжийг байгуулна.		
Сэлбэ голын хамгаалалтын зурвасыг шинэчлэн тогтоосны дагуу мэдээллийн санд оруулах.		
Иргэдийн оролцоотой ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод тарих.		
Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох эхний ээлжийн байршлуудад оршин суугчдын санал авах ажлыг зохион байгуулна.	Нийслэлийн зорилт	
Хууль тогтоомжийн дагуу иргэд, байгууллагад эзэмшүүлсэн, ашиглуулсан, өмчлүүлсэн болон Улсын тусгай хэрэгцээнд авснаас бусад газар буюу нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын зориулалттай 340.5 мянган га газрын бүртгэл, тооллого хийж, зурган мэдээлэлд оруулна.	Нийслэлийн зорилт	
Нийслэлийн иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Хотын ногоон бүсэд зуслангийн зориулалтаар эзэмшиж буй газрыг иргэдэд өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	Нийслэлийн зорилт	
Газар өмчлөлийн талаар нарийвчилсан мэдээлэл бүхий сан үүсгэж иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.	Нийслэлийн зорилт	
Хороолол доторх гражуудыг цэгцэлж, газар доогуур далд буюу давхар зогсоолуудыг барьж, Хашаа, Явган зам арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулна.		
Гэр хорооллын иргэдийн дунд тэдний санаачлага, оролцоон дээр тулгуурлан "Миний гудамж" төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, амьдарч буй орчноо сайжруулан өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлнэ.		

<b>3.2. Дэд бүтэц</b>		
Нийслэлийн авто замын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэн, гэр хорооллын болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн авто зам болон явган хүний замыг засварлана.		
Хүчит шонхор захаас Хувьсгалчдын гудамжны уулзвар хүртэлх 1.7 км авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгана.		
Шарга морьт-Жигжидийн уулзвараас Гүнтийн даваа чиглэлийн 5.0 км авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгана.		
ЧД, Гүнтийн зуслан чиглэлийн авто замаас Ар гүнтийн зуслан хүртэлх авто зам		
ЧД, 1-р хороо, зам талбайн доторхи зам талбайн борооны ус зайлуулах шугам		
Энхтайваны өргөн чөлөөний баруун хэсэг, Саппорогийн тойргоос Москвагийн гудамж -Үйлдвэрчний эвлэлийн гудамжны уулзвар-5 шар хүртэлх 3.2 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн дуусгах		
39-р сургуулийн зүүн урд талын уулзвараас Хүчит шонхор зах-эцсийн буудал хүртэлх 1.6 км авто замын өргөтгөл шинэчлэлт /ЧД, 11-р хороо/		
Баянбүрдийн тойргоос 32 тойрог хүртэлх 1.7 км авто замын шинэчлэлт / ЧД, 9, 10, 11-рхороо/		
Магнай трейдын ШТС-ийн уулзвараас Хайлаастын эцэс хүртэлх 3.1 км авто замын өргөтгөл шинэчлэлт/ ЧД 13, 16-р хороо/		
Долоон буудлаас Шарга морьтын зуслан чиглэлийн 10.3 км авто замын өргөтгөл шинэчлэлтийг хийнэ.		
Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хороодын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, “Гэрэлтэй гудамж” төсөл хөтөлбөрийг гэр хороололд хэрэгжүүлнэ.		
Хотын гэрэлтүүлгийг удирдлага хяналтын нэгдсэн сүлжээнд шилжүүлэх, камержуулах ажлыг хийнэ.		
Айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангаж, “Тог тасалддаггүй” дүүрэг болно.	Нийслэлийн зорилт	
Улаанбаатар хотын гэр хорооллын гэрэлгүй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдлийн уналттай айл өрхийн цахилгаан эрчим хангамжийг сайжруулна.	Нийслэлийн зорилт	
Баянхошуу дэд станцын өргөтгөлийг хийж дуусгана.	Нийслэлийн зорилт	
“Их тойруу” 110 кВ-ын 97 км ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2х40 мВА дэд станцын өргөтгөлийг дуусгана.	Нийслэлийн зорилт	
Алслагдсан гэр хорооллын айл өрхүүдийг нийтийн тээврийн үйлчилгээнд бүрэн хамруулах, нийтийн тээврийн чиглэл, маршрутыг уртасгах, автобусны буудлуудыг тохижуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		
Нийтийн тээврийн автобус, троллейбус болон эцсийн зогсоолуудыг тохижуулж камержуулан, иж бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.		
Олон жил болсон орон сууцны байруудын засвар, инженерийн шугам сүлжээг сайжруулна.	Нийслэлийн зорилт	
Орон сууцны хорооллын доторх шугам сүлжээг хонгилын системд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлийг үргэлжлүүлж, засварын цех байгуулна.	Нийслэлийн зорилт	
Орон сууцны болон гэр хорооллын хаягжилтыг бүрэн шинэчилж, “Чингэлтэйн хаягжилт” загвар төсөл хэрэгжүүлнэ.		
Орон сууцны хорооллын орчимд болон үйлчилгээний төвүүдэд ил ба газар доорх автомашины зогсоолуудыг бий болгоно.		
<b>Дөрөв. НОГООН ОРЧИН-БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨГЖИЛ</b>		
<b>4.1. БАЙГАЛЬ ОРЧИН</b>		
Агаарын бохирдлыг бууруулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэн, түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, бүрэн шаталттай зуухыг суурилуулах ажлыг эрчимжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих “Нэг өрх Нэг орон сууц” төслийг хэрэгжүүлнэ.		
Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих “Нэг өрх-Нэг орон сууц” төсөл хэрэгжүүлнэ.		
Хувийн хэвшлийн халаалтын зуухнуудад хэмжилтийн дагуу аттестатчлал явуулж, стандарт хангахгүй зуухнуудыг шинэчилнэ.	Нийслэл зорилт	
Халаалтын шинэ технологийг гэр хорооллын айл өрхүүдэд суурилуулна.	Нийслэл зорилт	

110-114

Усан халаалтын болон технологийн зориулалт бүхий зуухнуудыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Нийслэл зорилт	
Агаарын бохирдол, тоосжилтыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн, байгууллага, аж ахуйн нэгжийг орчны бичил цэцэрлэгт хүрээлэн, төгөлтэй болгоно.		
Төвийн цэцэрлэгүүдийг орчин үеийн хотын нийтлэг стандарт, шаардлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулна.	Нийслэл зорилт	
Сул шороон хөрс бүхий гудамж, талбайг үе шаттайгаар зүлэгжүүлэх буюу хатуу хучилттай болгох журам гаргаж, хэрэгжүүлж эхэлнэ.	Нийслэл зорилт	
Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад гадна орчноо тохижуулах, ногоон байгууламжтай болох хөдөлгөөн өрнүүлэн, байгууллагын эргэн тойрны 50 м газрыг зүлэгжүүлнэ.	Нийслэл зорилт	
Цэцэрлэгжилт, тохижилтгүй талбай бүхий албан байгууллага, аж ахуйн нэгжийн газар ашиглалтын төлбөрийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлсэн талбайн хэмжээнээс хамааруулан газрын ашиглалтын төлбөрөөс хөнгөлөх тогтолцоог нэвтрүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Гэр хорооллын 3 хороо бүрийн дунд хиймэл нуур, усан сан бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.	Нийслэл зорилт	
Орон сууцны болон гэр хорооллын нийтийн эзэмшлийн 1-2 талбайг амралт, чөлөөт цаг, спортын зориулалтаар тохижуулна.	Нийслэл зорилт	
Гэр хорооллын айл өрх, иргэдийн тоогоор "Мод тарих" хөдөлгөөнийг өрнүүлэн агаар, хөрсний бохирдол, тоосжилтыг бууруулах, ногоон байгууламжийн хэмжээг 2-оос 3 дахин нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.		
Ногоон бүс, Чингэлтэй хайрхан, Сэлбэ голын ай сав газарт иргэд, иргэдийн оролцоо, төрийн бус байгууллагатай хамтран "Эко бүлэг" байгуулан ойжуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.		
Засгийн газрын "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10.0 га газарт ногоон зурвас байгуулна.		
Усны эхийг хамгаалах зорилгоор ойжуулалтыг 100.0 га-аас доошгүй талбайд хийж гүйцэтгэнэ.		
Байгаль хамгаалах ажилд иргэдийн нөхөрлөл, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, гэр хорооллын гудамж, талбайг цэцэрлэгжүүлнэ.		
Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, хяналт шалгалт хийх зэрэг төрийн зарим чиг үүргийг байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүдтэй хамтран зохион байгуулна.		
Дүүргийн нутаг дэвсгэр дэх булгуудыг бүрэн тохижуулж, хамгаалалтад авна.		
Усан хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын хашлагыг үргэлжлүүлэн барьж, хамгаалалтын бүс доторхи аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттайгаар зогсооно.		
Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд айл өрх аж ахуйн нэгжүүдийн ашиглаж буй гүний худгийн тооллого зохион байгуулна.		
<b>4.2. ХОГ ХАЯГДАЛ, ХӨРСНИЙ БОХИРДОЛ</b>		
Хөрсний бохирдлыг бууруулан, иргэдийн оролцоотойгоор зуслангийн ногоон бүсийн айл өрхийг сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангана.		
Зуслан, ногоон бүсийн айл өрхийн жорлон, муу усны нүхийг ариутган, хөрсийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулна.		
Зуслангуудад сайжруулсан, 6 суултуур бүхий агааржуулагчтай бохир соруулах зориулалт бүхий тус бүр нь 6 суултууртай 15-аас доошгүй бие засах газар барина.		
Нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэн, хүн амын төвлөрөл ихтэй газруудад City Toilet-ыг, зуслангийн бүсэд 5-аас доошгүй бүрэн тохижилттой нийтийн бие засах газрыг бариулна.		
Хөрсний элэгдэл, эвдрэлд орсон газруудыг сэргээх, элэгдэл, эвдрэлд орох магадлал өндөр газруудад үерийн болон борооны ус зайлуулах далан, хамгаалалт барих ажлыг хийж гүйцэтгэнэ.		
Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар журам боловсруулан, мөрдөн ажиллана.		
Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.		
Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээний тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.		
Иргэн, аж ахуй нэгжийн оролцоог нэмэгдүүлэх замаар хог тээвэрлэлтийн менежментийг сайжруулан, хороодод "Эко эргүүл"-ийг тогтмол ажиллуулна.		

**Тав. ХЯНАЛТТАЙ ОРЧИН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ**

**5.1. НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ**

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан иргэд, хувиараа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж дарамт учруулж байгаа тогтоол шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авна.		
Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийтийн эрх ашигт нийцэхүйц Архи, тамхи хэрэглэдэггүй бүс болгох, Хог хаягдлын менежментийг сайжруулах, Хүүхдийн хүмүүжил, Чингэлтэйн хаягжилт, Нэг өрх Нэг орон сууц зэрэг төсөл хөтөлбөр боловсруулан, тогтоол шийдвэр гарган хэрэгжүүлнэ.		
"Цахим дүүрэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, онлайн сүлжээгээр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, тухай бүр хариу мэдэгдэж ажиллана.		
Дүүргийн нийт бүс нутгийг "Wi-Fi Free Zone" бүс болгон, дүүргийн нийт хүн амыг интернетэд нэвтрэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.		
Хороо бүрт иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах тусгай утас, шуудангийн хайрцаг ажиллуулж, дүүргийн хөгжлийн талаарх үр дүнтэй санал санаачлага гаргасан иргэн, байгууллагыг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.		
Нийслэлийн дүүрэг, хороодын үйл ажиллагааг "Эрүүл, аюулгүй байдлын индекс"-ээр хэмжиж урамшуулдаг тогтолцоог нэвтрүүлнэ.		
Бүх хороодод 7 хоногт 2-оос 3 өдөр газрын алба, нийгмийн даатгал, онцгой байдал, мэргэжлийн хяналтын алба зэрэг дүүргийн хэлтэс албадыг тогтмол ажиллуулж, төрийн үйлчилгээний ил тод, хүнд сурталгүй, хөнгөн шуурхай байдлыг ханган ажиллана.		
Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгэм болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тогтолцоог бүрдүүлж, шилдэг туршлагаудыг нэвтрүүлнэ.		
Төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх хорооны цогцолбор байрыг барих ажлыг үргэлжлүүлнэ.		
Дүүргийн болон хорооны төсвийн хуваарилалтыг иргэдэд ил тод, нээлттэй болгож нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.		
Иргэдийн амьдарч буй орчинд төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэх аливаа ажлыг эхлүүлэхээс өмнө иргэд, оршин суугчдаас асуудаг, санал хүсэлтийг нь сонсож шийдвэрлэдэг тогтолцоог бүрдүүлж, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үр дүнг иргэдэд эргэн тайлагнах хэлбэрийг төлөвшүүлнэ.		
<b>5.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</b>		
Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, иргэд аюулгүй тайван орчинд амьдрах баталгааг хангана.		
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хотын нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллыг телекамерын системд хамруулж, гэрэлтүүлгийг сайжруулна.	Нийслэлийн зорилт	
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоотойгоор интернет, мэдээллийн технологийг ашиглана.	Нийслэлийн зорилт	
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тодорхой эрхэлсэн ажилгүй иргэдийг эргүүл, хяналт шалгалтын ажилд татан оролцуулж, урамшуулал олгоно.	Нийслэлийн зорилт	
Нийгмийн дэг журмыг бэхжүүлэхэд дүүргийн төр захиргаа олон нийтийн болон мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийн түвшинг дээшлүүнэ.		
Нийгмийн хэв журмыг хамгаалахад зориулагдах техник хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.		
Цагдаагийн хэлтсийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Нийслэлийн зорилт	
Хайлаастын Цагдаагийн хэлтсийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	Нийслэлийн зорилт	
Замын хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгож, зам тээврийн осол хэргийн гаралтыг бууруулна.		
ЗЦГ-ын гэрээт албыг байгуулж ажиллуулна.	Нийслэлийн зорилт	
Жолооч нар бие биедээ хяналт тавих, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн бол тухай бүр ЗЦГ-т мэдээлэл өгдөг байх, мэдээллийн нууцыг хадгалж, урамшуулдаг тогтолцоог бий болгоно.	Нийслэлийн зорилт	

1111  
08

<b>5.3. Гамшгаас хамгаалах</b>		
Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах учирсан хохиролыг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх		
1. Дүүргийн Гамшгаас хамгаалах нөөц /хоол, хүнс, шатахуун, бусад биет материал/ бүрдүүлэх, холбоо, зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангах		
2. Дүүрэгт тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх, учирсан хохиролыг арилгах томилгоот бүрэлдэхүүний мэргэшүүлэн сургахад шаардагдах "Гамшгийн эрсдлийн сан" /хөрөнгө/ байгуулж төсөвт тусгаж ИТХ-аар батлуулах		
3. Гамшгаас хамгаалах Иж бүрэн болон хуульд заасан бүх төрлийн сургалтыг зохион байгуулах		
4. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нутгийн иргэдэд түшиглэсэн 4 дахь шатны гамшгийн менежмент төслийг хэрэгжүүлэх		
5. Дүүрэгт Гамшгаас хамгаалах улсын хяналтыг зохион байгуулж явуулан үр дүнг тооцон эрсдлийн үнэлгээ дүгнэлт хийж Засаг даргын шийдвэрт тусгуулан ажиллах		
6. Дүүргийн 19-р хороонд объектийн болон ой хээрийн түймрээс хамгаалах гал унтраах ангийн депо бариулах талаар холбогдох байгууллагад уламжлан дүгнэлт гаргуулан шийдвэрлүүлэх		
7. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, Онцгой комиссын түймэртэй тэмцэх хээрийн хөдөлгөөнт "Шуурхай штаб"-ыг шаардлагатай автомашин, багаж хэрэгслээр бүрэн тоноглож, бэлэн байдлыг хангана.		
8. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осолд өртсөн иргэд, хэлтсийн албан хаагчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх		
9. Монгол улсад Галын байгууллага үүсч байгуулагдсаны 90 жил, Хэлтсийн Аврах гал унтраах 10-р анги байгуулагдсаны 90 жил ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх дүүргийн ИТХ-ын тогтоол гаргуулан, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх		
<b>5.4. Цэргийн шинэчлэл</b>		
Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлж, цэргийн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, бүртгэлийн ажлыг программчлан, ашиглалтыг сайжруулна.		
1. Монгол Улсын Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэнд нь хяналт тавьж цэргийн мэргэжлийн удирдлага, туслалцаа дэмжлэг үзүүлэн төрийн батлан хамгаалах үйлчилгээг хэрэгжүүлэх		
2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид Батлан хамгаалах хуулийн хэрэгжилт, иргэдийн цэргийн үүргийн биелэлтийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх		
3. Дүүргийн хэмжээнд цэргийн тоо бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд хороодыг цэргийн тоо бүртгэлийн "Цахим хөтөлбөр"-ийн мэдээллийн баазыг өргөтгөх		
Орон нутгийн хамгаалалтын тогтолцооны үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, дайчилгааны томилгоот бүрэлдэхүүнтэй явуулах, цэргийн сургалт, бэлтгэлийг сайжруулна.		
1. Дайчилгааны томилгоот болон нөөц бүрэлдэхүүнтэй явуулах, цэргийн сургалт, бэлтгэлийн чанарыг дээшлүүлж, дайчилгаатай команд штабын хээрийн сургуульд оролцох		
2. Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын сургалт, бэлтгэлийг аюулт үзэгдэл, осол, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрээс хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажилд оролцох чадварыг нэмэгдүүлэх		
3. Дүүргийн хэмжээнд 2013 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг халалт, таталгын ажлыг зохион байгуулах		

119  
3

244  
64



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Дүүргийн 2012 оны нийгэм, эдийн засгийн  
зорилтын хэрэгжилтийг дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1д заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2012 оны нийгэм, эдийн засгийн зорилтын хэрэгжилтийг "бүрэн хангалттай" гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

2150010080



215 65



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Дүүргийн хөгжлийн санг байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах, хуваарилах, тайлагнах журмыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн баталж, Хурлын хороодын санал дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх эрхийг Хурлын Тэргүүлэгчдэд шилжүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

2150010088

БАТАЛГААНЫ ХУУДАС

Энэ хадгаламжийн нэгжид 65 хуудас + дотоод

товъёогны \_\_\_\_\_ хуудас бүгд 65 наарал тав  
/тоо, үсгээр/ /тоо, үсгээр/

хуудас дугаарлав.

Алгассан дугаар \_\_\_\_\_

Давхардсан дугаар \_\_\_\_\_

A3, A2 хэмжээтэй хуудасны дугаар \_\_\_\_\_

Дугтуй наасан, үдсэн хуудасны дугаар \_\_\_\_\_

Гэмтэлтэй, сэлбэн засагдсан хуудасны дугаар \_\_\_\_\_

Баталгааны хуудас бичсэн:

Хуучин /ажилтны албан тушаалын нэр/      Г. Ганзориг /гарын үсэг/      Г. Ганзориг /гарын үсгийн тайлал/

Огноо 2013.11.11